



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 15



Хураасан үр тариа өмнөх оноос 184.2 мянган тонн буюу 42.8 хувиар нэмэгдлээ

Газар тариалангийн салбарт нийт 17.5 мянган өрх, 1.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тариалан эрхэлдэг өрхийн 39.9 хувь нь Төвийн бүсэд, 20.1 хувь нь Хангайн бүсэд, 23.0 хувь нь Баруун бүсэд, 9.6 хувь нь Зүүн бүсэд, 7.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Харин тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 51.7 хувь нь Төвийн бүсэд, 21.3 хувь нь Хангайн бүсэд, 13.9 хувь нь Баруун бүсэд, 9.7 хувь нь Зүүн бүсэд, 3.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 онд нийт 675.1 мянган га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 87.2 (14.8%) мянган га-гаар өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ургамлын төрлөөр

	2018	2019	2020	2021	<u>2021</u> <u>2020</u>	Нийт тариалсан талбайн 432.6 (64.1%) мянган га-д үр тариа, 108.3 (16.0%) мянган га-д таримал тэжээл, 21.4 (3.2%) мянган га-д төмс, 11.2 (1.7%) мянган га-д хүнсний ногоо тус тус тариалсан нь өмнөх оноос үр тарианы талбай 24.7 (6.0%) мянган га, таримал тэжээлийнх 23.8 (28.2%) мянган га, төмснийх 2.4 (12.6%) мянган га, хүнсний ногоонынх 0.6 (6.1%) мянган га-гаар тус тус өссөн байна.
	мянган га				хувь	
Бүгд	507.9	523.1	587.9	675.1	114.8	
Үр тариа	366.8	369.4	408.0	432.6	106.0	
Буудай	342.4	343.5	377.0	392.5	104.1	
Төмс	12.9	14.9	19.0	21.4	112.6	
Хүнсний ногоо	8.9	8.4	10.6	11.2	106.1	
Таримал тэжээл	46.3	43.8	84.5	108.3	128.2	


Нийт тариалсан талбай 2021 онд 675.1 мянган га-д хүрсэн нь 1990-1992 оны түвшинтэй ойролцоо байна. Сүүлийн 30 гаруй жилийг авч үзэхэд 2006 онд хамгийн бага буюу 164.6 мянган га-д талбайд тариалалт хийсэн байна.

Нийт тариалсан талбайд үр тариа 1990-2005 оны дунджаар 90.5 хувийг эзэлж байсан бол сүүлийн 15 жилд буюу 2007-2021 онд 74.7 хувийг эзэлж байна. Энэ нь үр тариа нь газар тариалангийн голлох бүтээгдэхүүн хэвээр байгаа боловч нийт талбайд эзлэх хувь буурч, хүнсний ногоо, таримал тэжээл, техникийн ургамлын нэр төрөл нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Үр тариа тариалсан талбай өмнөх оноос Дундговь, Улаанбаатар хот, Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ аймагт 1.8 га-гаас 16.5 мянган га буюу 5.5-32.6 хувиар буурч, бусад аймагт 2.1 га-гаас 9.1 мянган га буюу 3.8 хувиас 2.8 дахин өссөн бол харин Баян-Өлгий аймагт өөрчлөлт ороогүй байна.

Үр тариа тариалсан талбай өмнөх оноос Дундговь, Улаанбаатар хот, Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ аймагт 1.8 га-гаас 16.5 мянган га буюу 5.5-32.6 хувиар буурч, бусад аймагт 2.1 га-гаас 9.1 мянган га буюу 3.8 хувиас 2.8 дахин өссөн бол харин Баян-Өлгий аймагт өөрчлөлт ороогүй байна.

ЗУРАГ 1. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, мянган га



Төмс тариалсан талбай өмнөх оноос Дундговь, Баянхонгор, Говь-Алтай, Булган, Увс, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт 0.9-242.5 га буюу 2.6-26.6 хувиар буурч, бусад аймагт 2.1 га-гаас 2.4 мянган га буюу 1.7-48.8 хувиар өссөн байна.

Хүнсний ногоо тариалсан талбай өмнөх оноос Дундговь, Баян-Өлгий, Сэлэнгэ, Увс аймаг болон Улаанбаатар хотод 0.7-164.9 га буюу 0.5-38.2 хувиар буурч, бусад аймагт 2.2-482.0 га буюу 0.4-37.7 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, мянган тонн

	2018	2019	2020	2021	<u>2021</u> <u>2020</u>
	мянган тонн				хувь
Үр тариа	453.8	433.3	430.3	614.5	142.8
Буудай	436.1	411.4	406.1	566.3	139.4
Арвай	2.4	2.5	3.2	11.7	3.6 ¹
Овьёос	10	13.3	16.6	33.2	199.7
Төмс	168.9	192.2	244.3	182.6	74.8
Хүнсний ногоо	100.7	99.5	121.2	121.7	100.4
Таримал тэжээл	123.8	121.1	182.1	293.7	161.3
Техникийн ургамал	23.9	34	22.6	52.3	2.3 ¹
Бэлтгэсэн хадлан	1 229.4	1 369.2	1 186.2	1 720.6	145.1

¹ Дахин их

Улсын хэмжээнд 2021 онд үр тариа 614.5 мянган тонн, төмс 182.6 мянган тонн, хүнсний ногоо 121.7 мянган тонн, таримал тэжээл 293.7 мянган тонн, техникийн ургамал 52.3 мянган тонныг хураан авч, 1.7 сая тонн хадлан, 63.6 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оноос

бэлтгэсэн хадлан 534.4 (45.1%) мянган тонн, хураасан үр тариа 184.2 (42.8%) мянган тонн, таримал тэжээл 111.5 (61.3%) мянган тонн, бэлтгэсэн гар тэжээл 21.4 (50.8%) мянган тонн, хураасан хүнсний ногоо 0.5 (0.4%) мянган тонноор тус тус өсөж, харин хураасан төмс 61.6 (25.2%) мянган тонноор буурсан байна.

Нийт хураасан үр тарианы 92.2 хувийг улаан буудай, 5.4 хувийг овьёос, 1.9 хувийг арвай эзэлж байна.

Хураасан үр тариа Дундговь, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Хэнтий аймагт өмнөх оноос 3.8 тонноос 4.4 мянган тонн буюу 21.8-71.4 хувиар буурч, харин бусад аймагт 12.7 тонноос 79.3 мянган тонн буюу 16.5 хувиас 4.4 дахин өссөн байна.


Хураасан төмс өмнөх оноос Дорноговь, Дорнод, Говьсүмбэр, Баян-Өлгий, Сүхбаатар, Завхан, Ховд, Архангай аймагт 23.4-890.9 тонн буюу 3.8-49.6 хувиар өсөж, бусад аймагт 52.6 тонноос 50.7 мянган тонн буюу 1.5-32.8 хувиар буурсан байна.

Хураасан хүнсний ногоо өмнөх оноос Өмнөговь, Говь-Алтай, Баян-Өлгий, Дархан-Уул, Увс, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт 20.3 тонноос 3.8 мянган тонн буюу 0.7-28.1 хувиар буурч, бусад аймагт 7.7 тонноос 2.4 мянган тонн буюу 0.5-38.1 хувиар өссөн байна.

Хураасан үр тариа 2021 онд 33.7 хувь нь Сэлэнгэ аймаг, 24.0 хувь нь Төв аймаг, 11.3 хувь нь Булган аймаг, 6.0 хувь нь Увс аймаг, 5.6 хувь нь Дорнод аймагт, хураасан төмсний 56.8 хувь нь Төв аймаг, 13.4 хувь нь Сэлэнгэ аймаг, 5.4 хувь нь Ховд аймаг, 4.3 хувь нь Дархан-Уул аймагт; хураасан хүнсний ногооны 30.0 хувь нь Сэлэнгэ аймаг, 18.3 хувь нь Төв аймаг, 14.1 хувь нь Дархан-Уул аймаг, 12.7 хувь нь Ховд аймагт тус тус ногдож байна.

Бэлтгэсэн хадлан өмнөх оноос Говьсүмбэр, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай, Дундговь, Баянхонгор аймагт 0.1-8.5 мянган тонн буюу 5.7-49.1 хувиар буурч, харин бусад аймаг болон Улаанбаатар хотод 2.1-117.4 мянган тонн буюу 10.4 хувиас 2.3 дахин өссөн байна.

ЗУРАГ 2. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, мянган тонн



Улсын хэмжээнд 2021 онд нэг га-гаас дунджаар 14.2 центнер үр тариа, 85.3 центнер төмс хураасан нь өмнөх оноос үр тарианых 3.7 (34.7%) центнерээр өсөж, төмснийх 43.1 (33.6%) центнерээр буурсан байна.


Үр тарианы га-гийн ургац 2021 онд Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Төв, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Орхон аймагт улсын дунджаас 0.5-18.1 центнерээр их, харин бусад аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.8-8.7 центнерээр бага байна.

Энэ онд олон жилийн дунджаас үр тарианы га-гийн ургац 2.0 центнерээр буюу 16.5%-аар их байна.

Төмсний га-гийн ургац Дундговь, Төв, Өмнөговь, Улаанбаатар хот, Говь-Алтай, Дорноговь аймагт улсын дунджаас 7.1-27.9 центнерээр бага, харин бусад аймагт улсын дунджаас 0.5-64.1 центнерээр их гарсан байна.

Энэ онд олон жилийн дунджаас төмсний га-гийн ургац 32.9 центнерээр буюу 27.9%-аар бага байна.

ЗУРАГ 3. ГА-ГИЙН УРГАЦ, центнер



Ойлголт, тодорхойлолт:

Нийт хураасан ургацыг тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлно.

Га-гийн ургац гэж талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.



Эх үүсвэр:

Өрх, аж ахуйн нэгж байгууллагын тариалсан талбайн жилийн мэдээ (А-ХАА7), Өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээ (А-ХАА-9), ХХААХҮЯ-ны мэдээ

Ангилал, код:

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Статитикч Х.Энхжавхлан
Утас : (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212